

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд
зайнаас хяналт тавих журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал” батлах тухай 82 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос банк бус санхүүгийн байгууллагын /цаашид “ББСБ” гэх/ үйл ажиллагаанд зайнаас хяналт хийх, үнэлгээ, дүгнэлт өгөх /цаашид “хяналт тавих” гэх/-д энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2 Хяналт тавих зорилго нь ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээ, хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан тайлан, холбогдох бусад мэдээ, мэдээлэл, судалгаа, тэдгээрт хийсэн тайлбар /цаашид тайлан, мэдээлэл гэх/-д үндэслэн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах буюу энэ талаарх саналаа Хорооны удирдлагад /цаашид удирдлага гэх/ танилцуулан холбогдох шийдвэр гаргуулахад оршино.

1.3 Хорооны хянан шалгагч нь /цаашид хянан шалгагч гэх/ холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журмын дагуу ББСБ-д хяналт тавьж ажиллана.

1.4 Хянан шалгагч нь хариуцсан ББСБ-тай аливаа ашиг сонирхлын зөрчилгүй, бие даасан, шударга байж, ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллана.

1.5 Хянан шалгагч нь хариуцсан ББСБ-ын эрх бүхий албан тушаалтантай холбоотой ажиллана.

ХОЁР. ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ

2.1 Хяналт тавих үйл ажиллагаа нь дараах дараалалтай байна. Үүнд:

2.1.1 Тухайн ББСБ-ын тайлан, мэдээлэлд үндэслэн үйл ажиллагааны болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.2 Тухайн ББСБ-ын үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөх;

2.1.3 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь шаардлагатай гэж үзвэл дараалсан хяналтыг хэрэгжүүлэх үүднээс ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх саналыг удирдлагад танилцуулж, гүйцэтгэх;

2.1.4 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь газар дээрх шалгалтын ажлын хэсгийг тайлан, мэдээллээр хангах, зайлшгүй шалгах шаардлагатай асуудлын жагсаалтыг гаргаж өгөх;

2.1.5 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагчийн өгсөн болон дараалсан хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг шалгах, түүний мөрөөр авах арга хэмжээний талаарх саналаа удирдлагад танилцуулж, шийдвэр гаргуулах.

ГУРАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭНД ХЯНАЛТ ТАВИХ

3.1 Хянан шалгагч нь хяналт тавихдаа ББСБ-д холбогдолтой дараах тайлан, мэдээллийг ашиглана. Үүнд:

3.1.1 Холбогдох заавар, журамд заагдсан болон Хорооноос шаардсан бусад тайлан, мэдээ, тайлбарын хамт;

3.1.2 Тухайн ББСБ-д хийсэн газар дээрх шалгалтын акт материал, танилцуулга;

3.1.3 Тухайн ББСБ-ын санхүүгийн тайлан мэдээг хөндлөнгийн хяналтын байгууллагаас хянасан тухай тайлан, дүгнэлт, түүний тайлбар;

3.1.4 Тухайн ББСБ-ын хяналтын зөвлөл, дотоод хяналтын алба, нэгжийн тайлан, мэдээ;

3.1.5 Тухайн ББСБ анх байгуулагдахад бүрдүүлж ирүүлсэн баримт материал, түүнд орсон аливаа өөрчлөлтийн талаар тухай бүр ирүүлсэн мэдээлэл;

3.1.6 Монголбанкны валютын ханшийн мэдээ;

3.1.7 Бусад мэдээлэл (харилцагчдын гомдол, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл, шүүх, хууль хяналтын байгууллагуудын тухайн ББСБ-тай холбогдуулан гаргасан шийдвэр г.м).

3.2 Хянан шалгагч нь хүлээн авсан тайлан, мэдээллийг дараах байдлаар хянана. Үүнд:

3.2.1 Тайлан, мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд нь бүрэн ирүүлсэн эсэх;

3.2.2 Эрх бүхий албан тушаалтнууд нь санхүүгийн тайлан, мэдээллүүдийг үнэн зөв гаргасан болохыг баталгаажуулан гарын үсгээ зурж, тамга, тэмдгээ дарсан эсэх;

3.2.3 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь Хорооноос мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцэж байгаа эсэх;

3.2.4 Тайлан, мэдээллийн үзүүлэлтүүдийг үнэн зөв гаргасан эсэх, тэдгээрийн уялдаа холбоо;

3.2.5 Өмнөх тайлант үеийн тайлан, мэдээлэл дэх үзүүлэлтээс үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээгээр өссөн болон буурсан үзүүлэлтүүдэд тайлбар хийсэн эсэх;

3.2.6 Газар дээрх шалгалтын акт материалтай тохирч /зөрчил, дутагдлыг арилгасан эсэх, активын ангилал ба активын эрсдэлийн санг бүрэн байгуулсан эсэх г.м/ байгаа эсэх.

3.3 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь энэ журмын 3.2-д заасан тайлан, мэдээлэл нь дутуу бол нэмж ирүүлэхийг, шаардлага хангаагүй бол залруулахыг шаардана.

3.4 ББСБ-аас ирүүлсэн тайлан, мэдээлэл нь хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй бол хянан шалгагч дараах арга хэмжээг шат дараалан авна. Үүнд:

3.4.1 Тайлан, мэдээллийг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээлэл нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй бол тухайн ББСБ-ын эрх бүхий албан тушаалтанд шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

3.4.2 Тайлан, мэдээлэл алдаатай, холбогдох заавар, журмын дагуу хугацаанд нь ирүүлээгүй зөрчлийг давтан гаргасан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, шаардлагатай гэж үзвэл, захиргааны хариуцлага ногдуулах;

3.4.3 Дээрх зөрчлийг давтан гаргасан, Улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах;

3.5 Хянан шалгагч нь тухайн ББСБ-аас ирүүлсэн улирал тутмын /шаардлагатай гэж үзвэл сарын тутмын/ санхүүгийн тайланд холбогдох тохируулгыг хийж, зохистой

харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцон, энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу тайлангийн хариуг боловсруулан, удирдлагад танилцуулж, тайлант хугацааны дараа сарын 25-ны өдрийн дотор тухайн ББСБ-д хүргүүлнэ.

3.6 Хянан шалгагч нь тухайн ББСБ-ын хянасан санхүүгийн тайланг тайлант хугацааны дараа сарын 20-ны өдрийн дотор нэгтгэлд хариуцсан хянан шалгагчид цахим хэлбэрээр өгнө

ДӨРӨВ. ББСБ-ЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

4.1 ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэл /цаашид нэгтгэл гэх/ хариуцсан хянан шалгагч нь ББСБ-ын санхүүгийн тайланг тухайн тайлант хугацааны дараа сарын 25-ны өдрийн дотор нэгтгэнэ.

4.2 Нэгтгэлийн үндсэн үзүүлэлтийн хураангуйд ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой санхүүгийн үзүүлэлтүүдийг нэгтгэлийн болон бүлгийн дунджаар гаргаж холбогдох тайлбар, дүгнэлтийг гаргаж, танилцуулга бэлтгэнэ.

4.3 Нэгтгэлийн танилцуулгад тухайн ББСБ хариуцсан хянан шалгагчаас тайлан тэнцэлд ямар тохируулга хийсэн тухай тайлбар, тодруулгыг гаргуулж, дараах үзүүлэлтүүдийн талаар он дараалсан судалгаа хийж, график дүрслэлийг хавсаргана. Үүнд:

4.3.1 ББСБ-ын нэгтгэлийн ерөнхий үзүүлэлтүүд;

4.3.2 актив, пассивын бүтэц, холбогдох харьцаанууд;

4.3.3 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт;

4.3.4 ашигт ажиллагааны үзүүлэлтүүд;

4.3.5 эрсдэлийн үзүүлэлтүүд;

4.3.6 эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журмын дагуу тооцох үзүүлэлтүүд болон нэгтгэлийн байдлыг илтгэх шаардлагатай бусад үзүүлэлтүүд.

4.4 Нэгтгэл хариуцсан хянан шалгагч ББСБ-ын нэгтгэл, танилцуулгыг улирал бүрийн дараа сарын 30-ны өдрийн дотор бэлэн болгож, удирдлагад танилцуулж баталгаажуулна.

ТАВ. ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ДҮГНЭЛТ БИЧИХ, ТАВИГДАХ ШААРДЛАГА, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь ББСБ-ын тухайн жилийн тайлант хугацааны санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварт өгөх зайнаас тавих дүгнэлт /цаашид дүгнэлт гэх/-ийг дараа оны эхний улиралд багтаан бичиж, удирдлагад танилцуулна.

5.2 Тухайн жилийн тайлант хугацааны дүгнэлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.2.1 энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан бүтцийн дагуу бүрэн гүйцэд бичин, эрсдэлийг үнэн зөв тодорхойлж, ойрын ирээдүйд санхүү, төлбөрийн чадварын хүндрэлд орж болзошгүй эсэхийг тогтоосон байх;

5.2.2 хяналтын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг биелсэн гэж үзэх боломжтой бол энэ тухайгаа бичих, боломжгүй гэж үзвэл авах арга хэмжээний тухай саналаа тодорхой тусгах;

5.2.3 тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь дүгнэлт өгөхдөө ББСБ-ын үзүүлэлтүүдийг авч үзэхээс гадна үйл ажиллагаа явуулах хэлбэр, цар хүрээний хувьд ижил төстэй бусад ББСБ-ын дундаж, үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзэх;

5.2.4 тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн өмнөх улирал, тайлант оны эхэн болон өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн байдал, түүний шалтгааныг илрүүлэн, санхүү, төлбөрийн чадвар болон бусад зохистой харьцаануудыг тооцоолон, үнэлгээ, дүгнэлт өгч, холбогдох үзүүлэлтийн динамик судалгааг графикаар гарган хавсаргах;

5.2.5 динамик үзүүлэлтүүдэд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийг цаг хугацааны дарааллын дагуу тусгах;

5.2.6 эрсдэлийг тооцох, түүний зах зээлийн өөрчлөлтийн мэдрэмжийг тодорхойлох үүднээс төрөл бүрийн шинжилгээний аргууд /Stress test, Z-score, Gap analysis/-ыг хэрэглэж, дүгнэлт гаргах;

5.2.7 гадаад, дотоодын үнэт цаас, хувьцаа эзэмшиж байгаа нөхцөлд зах зээлийн эрсдэлийн шинжилгээ болон зээлийн эрсдэлийн шинжилгээг хийх.

5.3 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь удирдлагад танилцуулсан дүгнэлтийг ББСБ-ын хувийн хэрэгт хадгална.

5.4 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдалд эрсдэл бий болсон нь тодорхой болсон буюу цаашид сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл дүгнэлтэд дараах асуудлуудын талаар дэлгэрэнгүй тусгаж, энэ талаар удирдлагад тухайлан мэдэгдэнэ. Үүнд:

5.4.1 уг зөрчил, дутагдал нь хууль тогтоомж, заавар, журмын холбогдох заалтыг ямар хугацаагаар, хэдэн удаа зөрчсөн;

5.4.2 уг зөрчил, дутагдалтай холбогдуулан тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагчаас авсан арга хэмжээний талаарх жагсаалт;

5.4.3 уг зөрчил, дутагдлыг гаргаснаар ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлсөн, цаашид ямар байдлаар нөлөөлөх;

5.4.4 зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний талаар тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагчийн санал.

5.5 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагч нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох саналаа Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэр гаргуулсан бол энэ тухай холбогдох байгууллагад мэдэгдэж, нийтэд мэдээнэ.

5.6 Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон ББСБ-д хяналт тавих үйл ажиллагааг дуусгавар болгож, хувийн хэргийг "Банк бус санхүүгийн байгууллагын хувийн хэргийг хөтлөх заавар" болон холбогдох бусад хууль тогтоомж, заавар, журмын дагуу Хорооны архивт шилжүүлнэ.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1 ББСБ нь санаатайгаар буюу санамсаргүйгээр тайлан, мэдээллийг алдаатай ирүүлсэн нь хянан шалгагчийн хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

6.2 Хянан шалгагч нь санхүүгийн тайлан мэдээг хянах, зайны хяналт хийх явцад тус байгууллага Хорооноос баталсан заавар журмыг зөрчсөн нь илэрсэн буюу илрэхээр зөрчил дутагдлыг засч, тохируулгын гүйлгээ хийгээгүйн улмаас дүгнэлт алдаатай гарснаас үүдсэн хариуцлагыг хүлээнэ.

6.3 Тухайн ББСБ-ыг хариуцсан хянан шалгагчийн хянасан санхүүгийн тайлангийн алдаа, тохируулгын гүйлгээ хийгээгүй хариуцлагыг нэгтгэл хариуцсан хянан шалгагч хүлээхгүй.

6.4 Нэгтгэл хариуцсан хянан шалгагч нэгтгэл, түүний дүгнэлтэд санаатай буюу санамсаргүй алдаа гаргасан бол хууль тогтоомж, заавар, журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

“..... ББСБ”ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-Д

Тайлангийн хариу

Танай ББСБ нь 20... оны дугаар сарын-ний өдрийн байдлаар ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээллийг /хугацаанд нь ирүүлсэн, хугацаа хоцроосон бол хэд хоног хоцроосныг бичих/ ирүүлсэн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13-р зүйлд заасан шаардлага болон Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	ББСБ-аас ирүүлсэн тайлангаар	Хянан шалгагчийн хянаж тооцсоноор	Зөрүү
1	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд			
А	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа (10 хувиас багагүй байх)			
Б	Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа (20 хувиас багагүй байх)			
В	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (10 хувиас багагүй байх)			
2	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт			
А	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (8 хувиас доошгүй байна)			
3	Актив хөрөнгийн төвлөрлийн эрсдлийн үзүүлэлтүүд			
А	Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр нь өөрийн хөрөнгийн (30 хувиас хэтрэхгүй)			
Б	ББСБ-ын хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив, төлбөрийн баталгаа:			
	Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгийн (10 хувиас хэтрэхгүй)			
	Нийлбэр нь өөрийн хөрөнгийн (25 хувиас хэтрэхгүй)			
В	Үнэт цаасны төвлөрлийн эрсдлийн үзүүлэлт			
	Нийт худалдан авсан үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь өөрийн хөрөнгийн (20 хувиас хэтрэхгүй)			

	Нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн (10 хувиас хэтрэхгүй)			
4	Активын эрсдлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт			
A	Активын эрсдлийн сангийн хүрэлцээ (+ илүү, - дутуу) /мянган төгрөгөөр/			
5	Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт			
A	Нэгж валютын хувьд (+/- 40 хувь)			
B	Нийт валютын хувьд (+/- 40 хувь)			
6	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт			
A	Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн дүн хувьцаат капиталын (80 хувиас хэтрэхгүй)			
7	Үндсэн хөрөнгийн үзүүлэлт			
A	Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн нийт активын (15 хувиас хэтрэхгүй)			

Танай ирүүлсэн тайлан тэнцлээс үзэхэд тайлант хугацаанд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг..... (бүрэн хангасан эсэх, хэрэв хангаагүй бол ямар үзүүлэлтийг, хэдий хугацаагаар хангаагүйг дүгнэж бичих)

(Тайлан мэдээг хугацаа хоцроосон, буруу гаргасан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт биелүүлээгүй зэрэг зөрчил гаргасан ББСБ-ын хувьд дараах байдлаар бичнэ:)

Танай ББСБ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн . . дугаар зүйлийн __ дэх заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын __ дэх заалтыг тус тус зөрчсөн тул (ямар арга хэмжээ авснаа бичих, ингэхдээ хуулийн үндэслэлээ тодорхой гаргах)

(Цаашид ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг зөвлөх)

.....-ЫН ГАЗРЫН ДАРГА

/...../

“..... ББСБ”ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАЙНААС ТАВЬСАН ХЯНАЛТЫН ДҮГНЭЛТ

/20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс
20... оны ... дугаар сарын ...-ны өдөр/

НЭГ. ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

1. Банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөл авсан огноо, шийдвэрийн дугаар:
2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулсан огноо, шийдвэрийн дугаар:
3. Хүчинтэй хугацаа:
4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:
5. Улсын бүртгэлийн дугаар:
6. Регистрийн дугаар:
7. Үүсгэн байгуулагдсан хэлбэр:
8. Өмчлөлийн хэлбэр:
9. Үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа /сараар/:
10. Албан ёсны хаяг, шуудан, утас, факсын дугаар:
11. Е-мэйл болон вэбсайт:
12. Үүсгэн байгуулагчдын тоо, нэр:
13. Хувь нийлүүлэгчдийн тоо:
14. ББСБ-ын үйл ажиллагааны төрөл, эрхлэх зөвшөөрөл авсан он, сар, өдөр:
15. ТУЗ-ийн даргын овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
16. ТУЗ-ийн гишүүдийн овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
17. Хяналтын зөвлөлийн даргын овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
18. Хяналтын зөвлөлийн гишүүдийн овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
19. ББСБ-ын бусад өндөр албан тушаалтнууд /дэд захирал, Ерөнхий зөвлөх г.м/-ын овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
20. ББСБ-ын гүйцэтгэх захирлын овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
21. Нягтлан бодогчийн овог, нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
22. Нийт харилцагчийн тоо /зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа, үйлчилгээ тус бүрээр/:
23. Нэгжийн тоо:
24. Нийт ажиллагсдын тоо:
25. Нийт банк бус санхүүгийн байгууллагын нийт активт эзлэх хувь:
26. Тухайн жилд аудит хийлгэсэн компани:
27. Санхүүгийн тайлангаа хэвлүүлсэн сонингийн нэр, дугаар:
28. Зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээ, төлсөн он, сар, өдөр:
29. Түдгэлзүүлсэн огноо, үндэслэл:
30. Хүчингүй болгосон огноо, үндэслэл:
31. Газар дээрх шалгалтын талаар /шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хэлбэр, хийсэн хугацаа, үнэлгээ/

ХОЁР. БАЛАНСЫН БҮТЭЦ /ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД/

А/. АКТИВ

Активын бүтэц:

Үзүүлэлтүүд	Тайлант үе		/мянган төгрөг/ Өмнөх оны тайлант үе	
	Дүн	Нийт активт эзлэх хувь	Дүн	Хувь
Мөнгөн хөрөнгө		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Богино хугацаат хөрөнгө оруулалт		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Зээлийн өрийн үлдэгдэл (цэвэр)		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэвэр/		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Нийт факторингийн тооцооны авлага /цэвэр/		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө /цэвэр/		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Бусад хөрөнгө		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Үндсэн ба биет бус хөрөнгө (цэвэр)		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Нийт актив		100.0%		100.0%
<i>Өөрчлөлт*</i>			-	%

Тайлбар: * -Тайлант үеийн дүнгийн өмнөх оны тайлант үеийн дүнгээс өөрчлөгдсөн дүн

Б/. ПАССИВ

Пассивын бүтэц:

Үзүүлэлтүүд	Тайлант үе		/мянган төгрөг/ Өмнөх оны тайлант үе	
	Дүн	Нийт пассивт эзлэх хувь	Дүн	Хувь
Итгэлцлийн үйлчилгээний өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Факторингийн үйлчилгээний өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%

Гадаад валютын арилжааны эх үүсвэр		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Төслийн зээлийн санхүүжилт		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Бусад пассив		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Нийт өр төлбөр		100.0%		100.0%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Хувьцаат капитал				
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Бусад өмч				
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Сангууд				
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Хуримтлагдсан ашиг/алдагдал				
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Хоёрдогч өглөг				
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Эзэмшигчдийн өмч		100.0%		100.0%
<i>Өөрчлөлт*</i>			-	%
Нийт пассив		100.0%		100.0%
<i>Өөрчлөлт*</i>			-	%

Тайлбар: * -Тайлант үеийн дүнгийн өмнөх оны тайлант үеийн дүнгээс өөрчлөгдсөн дүн

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

А/. ОРЛОГО

Орлогын бүтэц:

Үзүүлэлтүүд	Тайлант үе		Өмнөх улирал		/мянган төгрөг/ Өмнөх оны тайлант үе	
	Дүн	Нийт орлогод эзлэх хувь	Дүн	Нийт орлогод эзлэх хувь	Дүн	Нийт орлогод эзлэх хувь
Хүү болон түүнтэй адилтгах орлого		%		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%	-	%
Арилжааны орлого		%		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%	-	%
Ханш болон үнэлгээний гэгшитгэлийн орлого		%		%		%
<i>Өөрчлөлт*</i>			-	%	-	%
Санхүүгийн үйлчилгээний		%		%		%

орлого						
	Өөрчлөлт*			-	%	%
Бусад орлого		%			%	%
	Өөрчлөлт*			-	%	-
Нийт орлого		100,0%			100,0%	100,0%
	Өөрчлөлт*			-	%	-
Ашиг/алдагдал		%			%	%

Тайлбар: * -Тайлант үеийн дүнгийн өмнөх улирлын болон өмнөх оны тайлант үеийн дүнгээс өөрчлөгдсөн дүн

Б/. ЗАРЛАГА

Зардлын бүтэц:

Үзүүлэлтүүд	Тайлант үе		Өмнөх улирал		Өмнөх оны тайлант үе	
	Дүн	Нийт зардалд эзлэх хувь	Дүн	Нийт зардалд эзлэх хувь	Дүн	Хувь
Хүүгийн зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Боловсон хүчний холбогдолтой зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Бусад төрлийн зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Болзошгүй эрсдлийн зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Ердийн бус зардлууд		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Татварын зардал		%		%		%
	Өөрчлөлт*		-	%	-	%
Нийт зардал		100,0%		100,0%		100,0%
	Өөрчлөлт*		-	%	-	%

Тайлбар: * -Тайлант үеийн дүнгийн өмнөх улирлын болон өмнөх оны тайлант үеийн дүнгээс өөрчлөгдсөн дүн

ДӨРӨВ. ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Дараах үзүүлэлтүүдийг тайлант үеийн эцсийн байдлаар тооцож тус бүрд нь холбогдох үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

1. Зээл болон түүнтэй адилтган тооцох бусад активын төвлөрлийн үзүүлэлт, шинжилгээ:

- Нэг зээлдэгчид олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын өөрийн хөрөнгөтэй харьцсан харьцаа:
- Холбогдох этгээдэд олгосон зээл /нэг болон нийт этгээдийн хувьд/, түүнтэй адилтган тооцох активын өөрийн хөрөнгө болон нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ:
- Нийт чанаргүй зээлийн багцад эзлэх холбогдох этгээдэд олгосон зээлийн хувь хэмжээ:

2. Активын багцын эрсдлийн шинжилгээ:

- Эрсдэлээр жигнэсэн цэвэршүүлсэн нийт актив, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа:
- Эрсдэлээр жигнэсэн актив нийт активын харьцаа:
- Зээлийн ангилал тус бүрийг нийт зээлийн өрийн үлдэгдлийн дүнд харьцуулсан харьцаа:
- Зээлийн эрсдлийн сан, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа:
- Хүүгийн орлого оруулдаг актив, нийт актив болон активын өгөөжтэй харьцуулж, өгөөжийн үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох:
- Хүүгийн орлого оруулдаггүй актив, нийт активын харьцаа:
- Зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа /зээлийн өрийн үлдэгдлийг зээлийн эрсдлийн сангаар цэвэршүүлээгүй дүнгээр авах/:
- Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн нийт активын харьцаа:
- Шаардлагатай тохиолдолд бусад үзүүлэлтүүдийн талаар тусгах:
- Шаардлагатай бол огцом өөрчлөлт гарсан бусад үзүүлэлтүүдийн талаар тусгах:

3. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд:

- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн нийт активын харьцаа:
- Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн нийт активын харьцаа:
- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа:
- Шаардлагатай тохиолдолд бусад үзүүлэлтүүдийн талаар тусгах:
- Шаардлагатай бол огцом өөрчлөлт гарсан бусад үзүүлэлтүүдийн талаар тусгах:

4. Төлбөрийн чадварын шинжилгээ:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг төгрөг, гадаад валютын нийт дүнгээр тус тус тооцно.

5. Орлого, зарлага, ашигт ажиллагаанд үндэслэн гаргах харьцаа /шинжилгээ/:

ББСБ-ын орлого, зарлагын бүтэц, тэдгээрийн өөрчлөлтийн байдлыг авч үзэхдээ ББСБ-ын явуулж байгаа бодлого, стратеги төлөвлөлтийн байдалтай харьцуулан авч үзэж, улирлын болон түр зуурын шинж чанартай эсэхийг харгалзан үнэлэлт дүгнэлт хийнэ.

- Хүүгийн цэвэр орлого ($ХЦО = ХО$ /зээлийн хүүгийн орлого, үнэт цаасны хүүгийн орлого, бусад хүүгийн орлого / - $ХЗ$ /төлбөртэй эх үүсвэрт төлсөн хүү/ :)
- Санхүүгийн зуучлалын цэвэр орлого ($ЗЦО = ХЦО$ ($ХО$ /зээлдэгчдээс авсан хүүгийн орлого/- $ХЗ$ /төлбөртэй эх үүсвэрт төлсөн хүү/) - $ЗБАХС$):
- Үйл ажиллагааны нийт орлого ($ҮАНО = ЗЦО +$ бусад үйл ажиллагааны орлого - бусад үйл ажиллагааны зардал):
- Үйл ажиллагааны цэвэр орлого ($ҮАЦО = ҮАНО -$ Үйл ажиллагааны зардал /цалин, цахилгаан/):

- Татварын өмнөх орлого ($T\Theta O = Y\Delta CO + \text{Бусад элдэв орлого /үнэлгээний өөрчлөлт г.м/-Бусад элдэв зарлага /ханиш.../}$):
- Татвар төлсний дараах орлого ($TDO = T\Theta O - \text{Татвар}$):
- Ашиг болон активын өсөлтийн харьцаа:
- Хүүгийн цэвэр зөрүү (Хүүгийн орлого, хүүгийн зарлагын зөрүүг орлого оруулдаг активын дунджид харьцуулсан харьцаа):
- Шаардлагатай тохиолдолд бусад үзүүлэлтүүдийн талаар тусгах:
- Шаардлагатай бол огцом өөрчлөлт гарсан бусад үзүүлэлтүүдийн талаар тусгах:

Ашигт ажиллагааг илэрхийлэх дараах үзүүлэлтүүдийг жилээр тооцож, шаардлагатай бол тус бүрт нь холбогдох үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

- Хүүгийн орлого, нийт дундаж активын харьцаа:
- Хүүгийн зардал, нийт дундаж активын харьцаа:
- Хүүгийн цэвэр орлого, нийт дундаж активын харьцаа:
- Хүүгийн бус орлого, нийт дундаж активын харьцаа:
- Хүүгийн бус зардал, нийт дундаж активын харьцаа:
- Үйл ажиллагааны цэвэр орлого, нийт дундаж активын харьцаа
- Болзошгүй эрсдэлийн зардал, нийт дундаж активын харьцаа:
- Татварын өмнөх орлого, нийт дундаж активын харьцаа:
- Хүүгийн орлого, хүүгийн орлого оруулдаг нийт дундаж активын харьцаа:

Үр дүнгийн шинжилгээний дүгнэлтийг хийхдээ дараах үзүүлэлтүүдэд тулгуурлана. Үүнд:

- Нийт өөрийн хөрөнгийн өгөөж:
- Хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн өгөөж:
- Активын өгөөж:

Ашгийн өсөлт, бууралтад үнэлэлт дүгнэлт өгөхдөө дараах шинжилгээнүүдэд тулгуурлана. Үүнд:

- Ашиг болон активын өсөлтийн харьцаа: Ашиг /алдагдал/-ийн өсөлтийг активын өсөлтөд харьцуулна.
- Санхүүгийн зуучлалын үр ашиг: Хүүгийн орлого, хүүгийн зарлагын зөрүүг орлого оруулдаг активын дунджид харьцуулна.
- Үр ашгийн үзүүлэлт: Үйл ажиллагааны зардлыг нийт үйл ажиллагааны орлогод харьцуулан тооцно. Энэ үзүүлэлт хэдий чинээ бага байна тэр хэмжээгээр ББСБ-ын үйл ажиллагааны үр ашиг сайн байна гэж үзнэ.

6. Бусад эрсдлийн шинжилгээ

- Зах зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэл (Gap analysis), үйл ажиллагааны эрсдэл, гадаад валютын ханшийн эрсдэл, хууль тогтоомж, эрх зүйн орчны эрсдэл, нэр хүндийн эрсдэл зэргийг тооцно.

ТАВ.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТҮҮНД ГАРСАН ӨӨРЧЛӨТҮҮД

-Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд гарсан бүх өөрчлөлтүүдийг бичнэ.

ЗУРГАА. ТУХАЙН ХУГАЦААНД ТУС ББСБ-Д САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН ХОЛБОГДОХ

**ЭРХ БҮХИЙ БУСАД БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Арга хэмжээ авсан байгууллагын нэр	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний		Зөрчил	Арга хэмжээний товч утга
		хэлбэр	огноо		
	1. Хорооноос авсан албадлагын арга хэмжээ				
	.				
	.				
	.				
	2. Хорооноос авсан бусад арга хэмжээ				
	.				
	.				
	.				
	3. Холбогдох эрх бүхий бусад байгууллагаас авсан арга хэмжээ				
	.				
	.				
	.				

Жич: Хорооноос авсан албадлагын арга хэмжээнд Хорооны хянан шалгагч, Улсын байцаагчийн тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэвэр, хугацаат үүрэг даалгавар өгөх тухай албан тоот бичиг, Хорооны тогтоол, шийдвэр зэрэг орно. Бусад арга хэмжээнд тус ББСБ-д Хорооноос явуулсан бусад албан тоот, тогтоол, шийдвэр орно. Холбогдох эрх бүхий бусад байгууллагаас авсан арга хэмжээний жагсаалтыг тухайн байгууллагуудаас ББСБ-тай холбогдуулан Хороонд ирүүлсэн баримт бичгийг үндэслэж гаргана.

ДОЛОО. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

-Үндэслэл бүхий үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулна.

НАЙМ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

- Тухайн ББСБ хариуцсан хянан шалгагчийн гаргасан тайлан тэнцэл болон холбогдох тайлан, мэдээллүүд;
- Шаардлагатай бол ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээллүүд;
- Дүрмийн сангийн хувь хэмжээ, бүтцийн талаарх мэдээллүүд;
- ББСБ-ын нэгжийн талаарх мэдээллүүд

“.....ББСБ”ХХК-ийн үйл ажиллагаанд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийн I дүгээр хавсралт

**“.....ББСБ”ХХК-ИЙН ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЭЦ,
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

/.... оны ..-р улирлаас мөн оны ...-р улирлыг хүртэл/

/огноо: он.сар.өдөр/

Д/д	Хувь нийлүүлэгчдийн		Дүрмийн санд оруулсан хөрөнгийн хэмжээ		Дүрмийн санд хувь хөрөнгө оруулсан огноо	Дүрмийн санд эзлэх хувь	Тайлант хугацаанд дүрмийн сангийн хэмжээнд гарсан өөрчлөлт	Тайлант хугацаанд дүрмийн сангийн бүтцэд гарсан өөрчлөлт	
	Нэрс	Дугаар		төрийн					хувийн
		Улсын бүртгэлийн	Регистр						
Нийт									

Жич: 1. Тайлант хугацаанд дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэн бол +, хасагдсан бол - гэсэн тэмдэглэлийг дүрмийн сангийн хэмжээнд гарсан өөрчлөлт гэсэн баганад ашиглана.

2. Хэрэв хэт олон хувь нийлүүлэгчтэй бол эзэмших хувьцааных нь нийлбэр нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзлэх хамгийн том хувь нийлүүлэгчдийн талаарх мэдээллийг бичнэ.

“.....ББСБ”ХХК-ийн үйл ажиллагаанд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийн 2 дугаар хавсралт

“..... ББСБ”ХХК-ИЙН НЭГЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

/.... оны ..-р улирлаас мөн оны ...-р улирлыг хүртэл/

/огноо: он.сар.өдөр/

Д/д	ББСБ-ын салбар нэгжийн			Тайлант хугацаанд ББСБ-ын салбар нэгжийн тоо, бүтэц, байршилд гарсан өөрчлөлт
	Байршил, албан ёсны хаяг	Үүсгэн байгуулагдсан огноо	Утас, факсын дугаар	